

ХЯТАДЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДИТ ДҮР ТӨРХ БА СТРАТЕГИЙН ТУСГАЛЫГ ӨӨРЧЛӨХ ХЭРЭГТЭЙ

*Ян И**

Шинэ Хятад улс байгуулагдсанаас хойшхи гадаад харилцааны стратегийн хөгжлийг гурван үе шатанд хувааж болно.

1 дүгээр шат нь: 1949-1978 он, гол илрэл нь гадны аюул заналыг эсэргүүцэж, БНУ-ын аюулгүй байдлыг хангах явдал байв. Шинэ Хятад улс байгуулагдсаны дараа гаднын ихээхэн аюул занал тулгарч байсан бөгөөд Хятадын гол зорилт нь оршин тогтнолоо бататгах явдал байсан нь тэмцээнд “нягт хамгаалалт” хийхтэй адил байв. Гэвч Хятад идэвхгүй хамгаалалт хийлгүй идэвхтэй хамгаалалт хийж, энэ үед Африк тивтэй харилцаагаа хөгжүүлж байв.

2 дугаар шат нь: шинэтгэл нээлттэй бодлогоос хойш өнгөрсөн зууны төгсгөл хүртэл “хамгаалалтаас сөрөг довтолгоонд орох” үе байв. Хятад улс өрнөдийн орнуудтай сөргөлдөөний талбарт хамгаалалтаас сөрөг дотолгоонд оров. Байдал тийм ч идэвхгүй бус байсан. Хятадын нөлөө гадаадад хүндэтгэл олох болов.

3 дугаар шат нь: шинэ зуунаас өнөөг хүртэлх “бүх талаар довтолж бүрэн хамгаалалт”-ын үе шат юм. Нэгдмэл хятад үндэстэн сэргэн мандаж эхлээд Хятадын нөлөөлөх хүч, улсын нийт хүчин чадал өдрөөс өдөрт өсөн дээшилж байна. Хятад өрнөдийн улсуудтай хэдийнэ “бүх талаар довтолж, бүрэн хамгаалалт хийж” болохоор байгаа ч нилээд болхи үедээ байна. Ийнхүү гурван үе шатанд хуваах нь төдий л шинжлэх ухааны үндэслэлгүй бөгөөд түүнд давхцал солбилцол байгаа ба мөн сольж хуваарилах үйл явц ч явагдаж байна.

Өнөөгийн Хятад түүхэн хөгжлийн үе шатны шинэ эхлэлтийн үедээ байна. Хятадын олон улсын үүрэг рольд гурван чухал өөрчлөлт гарч байна.

Нэгд: Хятад бүс нутгийн их улс байснаа даяаршил мөн дэлхийн их гүрэн болон өөрчлөгдөж, Хятадын ашиг сонирхол Хятадын нөлөөний хүч дэлхий дахинд алхам алхмаар чиглэж, Хятадын стратегийн тусгал ч түүнийг даган өөрчлөгдөж байна.

Хоёрт: Хятад олон улсын тогтолцоонд хавсран тоглогчийн рольтой байснаа голлон тоглогч болж байна. Ялангуяа дэлхийн санхүүгийн хямрал Хятадыг дэлхийн тавцангийн төвд хугацаанаас нь өмнө гаргаж, Хятадын “хариуцлагын ухамсар” болон “тохиолдлын ухамсар” үүнийг даган өсөж байна.

Гуравт: Хятад “ганцаарчилсан тоглогчоос” “олон чадвартай тамирчин” болон хувирч, улс төр, эдийн засаг, соёл, гадаад харилцаа, цэрэг зэрэг бүхий л салбарт дэлхийд үүрэг роль гүйцэтгэх хэрэгтэй байгаа бөгөөд нэн түрүүнд энэ талаар бодож эрэлхийлэх ба бэлтгэх хэрэгтэй байна.

Эдгээр өөрчлөлтийн явцад Хятадад тулгарч буй асуудал нь урьд өмнө аливаа их гүрэнд тулгарч байснаас үлэмж их байх юм. Нэн түрүүнд,

* Ян И - Хятадын Батлах хамгаалах их сургуулийн стратеги судалгааны хүрээлэнгийн профессор

дэлхий ертөнцөд хятадын онцлогтой социализм болон хүйтэн дайны үзэл санаа сөргөлдсөөр байгаа учраас өрнөдийн улсууд Хятадын үндэсний нийт бүтээгдэхүүн нэн өндөр байгааг “тариачны үйлдвэрлэл”, “хотын өрх амд харьяалагддаггүй” өөр төрөл гэж үзэж байна. Түүнчлэн өрнөдийн зарим улс Хятадын энх тайван хөгжлийг дайн өдөөх явдал гэж үзээд, нэгдмэл хятад үндэстний сэргэн мандал болон тогтолцоогоо барьж байгаа төрийн мөргөлдөөн гарах нь зайлшгүй гэж үздэг. Хятадын түргэн хөгжил нь Хятад болон хөгжиж буй улсуудын харилцаанд ихээхэн өөрчлөлт оруулж, зарим уламжлалт найрамдалтай улсууд Хятадад элдэв санал тавих болсон.

Эдгээр шинэ, өөрчлөлттэй тулгарах, Хятад улс гадаад бодлогодоо гурван томоохон хариу арга хэмжээ авах болсон. Үүнд: өөрчлөлтөд бүх талаар оролцох, цаг тухайд нь хариу үйлдэл үзүүлэх болон санаачилгыг авах явдал юм.

Хятад улсынхаа эрх ашгийг хамгаалахад бүх талаар идэвхитэй оролцох~ хятадын цөм эрх ашиг хөндөгдөх үед цаг тухай бүрд нь байр сууриа тодорхой илэрхийлэх~ дипломат уламжлалд шинэ агуулгыг бий болгож, тоглоомын дүрмийг өөрчилөхөд нөлөөлөх хэрэгтэй. Хятад олон улсын эрх ашгийг стратеги бодлогынхоо төвд байлгаж, улсын хүчин чадлыг баримжаа болгож, өөрийн хүчээр лавтай, хүчин төгөлдөр хамгаалах ёстой.

Шанхайн олон улс судлалын хүрээлэнгийн “Гозы жаньван” (Олон улсын ажиглалт) сэтгүүлийн 2010 оны 9-10 дугаар сарын №8

*Хятад хэлнээс орчуулсан: Х.Цэгмэд (“Түгээмэл” дээд сургуулийн хятад хэлний багш),
Л.Бэгзжав*